



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар

А/32

Амардалай

“Баялаг бүтээгчдийг дэмжих жил” болгон
зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а”, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Орон нутгийн хэмжээнд төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаанд түшиглэсэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оныг “Баялаг бүтээгчдийг дэмжих жил” болгон зарласугай.

Хоёр: “Баялаг бүтээгчдийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөг санал, эрэлт хүсэлтэд тулгуурлан боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлт, үр дүнг тооцон ажиллах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Гишүүдэд: Засаг даргын Тамгын газрын дарга

Сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

Багийн Засаг дарга нар

ХАА, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн

ХЭХАХ хариуцсан мэргэжилтэн

4880100094

Гурав: Орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийг худалдан авах ажиллагаанд оролцоход давуу эрх олгох замаар дотоодын ажлын байрыг хадгалах, бизнес эрхлэгчдийн ашиг орлогыг нь хамгаалах, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, хамтран ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /С.Нарантунгалаг/-т даалгасугай.

Дөрөв: 2021 онд ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах ажлын хүрээнд гарах зардлыг ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас гаргахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/, нягтлан бодогч /Д.Долгорсүрэн/ нарт зөвшөөрсүгэй.

Тав: Орон нутагт баялаг бүтээхэд бүтээлч санаачлага, бодитой үр дүн гаргаж хамтран ажиллахыг сумын нийт бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалсугай.

ДАРГА



М.БАЯРСҮХ

